ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ
ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ

2024



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ

# ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ 2024

МАНДАЛГОВЬ

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.МӨНХБАТ
2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

БАТЛАВ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ОДБАЯР
2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2024.02.05 Мандалговь хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйл, 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.17 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 37, 38 дугаар зүйлийг тус тус үндэслэн ,

1.1. Энэхүү гэрээг нэг талаас аймгийн Засаг дарга Ц. Мөнхбат, нөгөө талаас Дэлгэрхангай сумын Засаг дарга Ц.Одбаяр нар 2024 оны 01 дүгээр сарын 2-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусталх хугацаатай байгуулав.

1.2. Тус хамтран ажиллах гэрээ нь сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газар болон УИХ-ын тогтоол шийдвэрийг төлөөлөн хэрэгжүүлж, сум байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгэний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан үүрэг хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож үр дүнг үнэлж дүгнэх зорилготой.

1.3. Гэрээний хэрэгжилтийг хангахад Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

1.4. Гэрээнд сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсаргах бөгөөд энэ гэрээний салшгүй хэсэг байна.

1.5. Гэрээний биелэлт нь сумын Засаг даргад урамшуулал олгох, хариуцлага тооцох үндэслэл болно.

**Хоёр.Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг**

2.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

2.2. Гэрээний биелэлтийг хангах, үр дүнг дээшлүүлэх талаар шаардлага тавих

2.3. Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд сумын Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах, хамтран ажиллах гэрээний төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

2.4. Хууль тогтоомжийн дагуу Төрийн захиргааны төв байгууллагад хандан тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, орон нутагт байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг дэмжих

2.5. Эх үүсвэр харгалзахгүй тухайн онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хугацаа хоцорсон, чанарын шаардлага хангаагүй ажлуудыг чанартай гүйцэтгүүлэхийг шаардах, дурдсан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авах

2.6. Гэрээний нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, үйл ажиллагаагаа уялдуулж ажиллах

2.7. Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах

2.8. Гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх

2.9. Хууль тогтоомжид заасан бусад ;

**Гурав. Сумын Засаг даргын хүлээх үүрэг**

3.1. "Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал"-ын чиглэлээр төлөвлөгөө боловсруулж үр дүнг тооцон ажиллах

3.2. Хүүхэд хамгааллын хүрээнд болзошгүй эрсдэлээс хамгаалсан аюулыг илрүүлэх, арилгах талаар санал санаачилга гарган ажиллах

3.3. Ид шидтэй өрөө байгуулж менежмент хийх

3.4. Аймгийн Засаг даргын 02 дугаар захирамжаар "Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалгыг" хэрэгжүүлж соёлыг дэлгэрүүлэх

3.5. Хог хаягдлаа ангилан ялгах, хоёрдогч түүхий эд авах цэгүүдэд нийлүүлэх

3.6. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулах

3.7. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль", "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын хэрэгжилтийг хангах

3.8. "Цахим сум" аяны хэрэгжилтийг хангаж ажиллах

3.9. Төрийн албан хаагчдын орон сууцны хангалтыг нэмэгдүүлэх

3.10. Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр, санхүүжүүлэгч байгууллагууд (Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд)-д нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлэх

3.11. Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, үр дүнг тооцох

3.12. Сумын төсөвт 2024 онд гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг тусган, шийдвэрлэж ажиллах

3.13. Аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээнд суманд тулгамдаж байгаа асуудлыг шийвэрлүүлэх тал дээр санаачлагатай ажиллаж гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож тайлагнах

3.14. Санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйн удирдлагаар хангах, өмнөх оны өр төлбөр, авлагыг бүрдүүлэх, улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хангаж биелүүлж үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцах

3.15. Гадаад айлчлал, арга хэмжээ, уулзалт зохион байгуулах бүрд аймгийн Засаг даргын Тамгын газар, салбарын яамны холбогдох албан тушаалтнаас удирдлага чиглэл авч, айлчлалын илтгэх хуудас, ярианы тэмдэглэл бичин дүгнүүлж хэвших, айлчлалын үр өгөөжийг тооцож, үр дүнгүй айлчлал хийхийг хязгаарлах

3.16. "Ажлын сахилга, хариуцлагыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, "Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах тухай" Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар захирамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдөж ажиллах

3.17. Аливаа аймаг болон сум, орон нутгаас зохион байгуулахаар төлөвлөгдсөн нэгдсэн арга эмжээнд хөдөөгийн иргэдээ бүрэн хамруулах, тэдний санал бодлыг сонсох ажлыг уялдуулан зохион байгуулах

3.18. Аймгийн удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллах

**Дөрөв. Гэрээг дүгнэх, үнэлэх**

4.1. Сумын Засаг дарга гэрээний эхний хагас жилийн биелэлтийг 2024 оны 5 **дугаар сарын 25-ны,** жилийн эцсийн биелэлтийг **12 дугаар сарын 01-ний** дотор багтаан харьяа хэлтсүүдэд тайлагнаж, **төсвийн ерөнхийлөн захирагч** эхний хагас жилийн биелэлтийг 2024 оны **6 дугаар сарын 10-ны**, жилийн эцсийн биелэлтийг **12 дугаар сарын 10-ны** дотор багтаан дүгнэнэ.

4.2. Гэрээний үүргийн биелэлтийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1, журмын 10б хавсралтад заасан аргачлалын дагуу дүгнэж, тайлагнана.

б/ Засаг даргын Тамгын газраар үнэлүүлэх

**Тав. Гэрээ дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох**

5.1.Сумын Засаг дарга гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Сумын Засаг дарга гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч түүнд туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Зургаа. Маргааныг шийдвэрлэх**

6.1. Хөтөлбөрийн өртгийг тодорхойлох, санхүүжилтийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зохицуулах арга хэмжээ авна.

6.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

6.3. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж, зөвлөгөө авч ажиллана.

**Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах**

7.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн Аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нар гарын үсэг зурж, гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эх хувь тус бүрийг аймгийн Засаг дарга болон сумын Засаг дарга хадгална.

7.3. Гэрээнд тусгагдаагүй хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлыг талууд харилцан зөвшилцөж, аймгийн ИТХ-д оруулан шийдвэрлэсний үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно.

7.4. Шаардлага гарсан тохиолдолд харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээг цуцалж болно.

**Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

**Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргын**
**2024 онд хамтран ажиллах гэрээний**
**1 дүгээр хавсралт**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2024 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023 | Хүрэх түвшин 2024 | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| | **1. Хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ** | | | | | |
| 1 | Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон гаргах | | Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80 | 90 | Сумын ЗДТГ |
| 2 | Төрийн жинхэнэ албан хаагчийг Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах | УТ ОНТ | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | - | 2 | Сумын ЗДТГ |
| 3 | Төрийн албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу бүрэн шинэчлэн бүрдүүлэх | - | Хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлсэн албан хаагчийн тоо | - | Сум тус бүрийн төрийн албан хаагчийн тооноос хамаарч гүйцэтгэлээр | Сумын ЗДТГ |
| | **2. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх** | | | | | |
| 4 | Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг бүртгэн | | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь | 98.7 | 99 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн хугацаанд шийдвэрлэх | | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг улирал бүр ТЗУХ-т хүргүүлэх | Тайлан хүргүүлсэн тоо | 4 | Сумын ЗДТГ |
| **3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 5 | Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллах | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 80 | 90 | Сумын ЗДТГ |
| | | | Тайланг хугацаандаа ирүүлсэн байх | 2 | 2 | |
| 6 | Аймгийн стратеги төлөвлөгөө, АЗДҮАХ үйл ажиллагаанд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж хэрэгжилт үр дүнг тооцох | | Заалтын хэрэгжилтийн дундаж хувь | - | 90 | Сумын ЗДТГ |
| **3. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | | | | | | |
| 7 | “Цахим шилжилт-Цахим Дундговь” цогц арга хэмжээний хүрээнд цахим сум аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 80 | Сумын ЗДТГ |
| 8 | Сумын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллах | | 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулсан хэрэгжилтийн хувь | 45.8 | 100 | Сумын ЗДТГ |
| 9 | Тухайн сумын албан ёсны фэйсбүүк хуудсыг идэвхжүүлж хандалтын тоог нэмэгдүүлэн аймаг, орон нутгийн мэдээллийг түгээх | | Түгээсэн мэдээллийн тоо | 30 | 40 | Сумын ЗДТГ |
| | | | Хандалтын тоо | | | |
| **4. Гадаад харилцааг орон нутагт хэрэгжүүлэх** | | | | | | |
| 7 | Гадаад улсын ижил түвшний орон нутаг, байгууллагатай гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулахдаа гэрээний төслийг 10-аас доошгүй өдрийн өмнө ирүүлж зөвшөөрөл авах | - | Зөвшөөрөл авч гэрээ байгуулсан эсэх /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Гадаад хамтын ажиллагааны хагас жилийн мэдээг 05 дугаар сарын 20-ний өдрийн дотор, жилийн эцсийн тайлан, ирэх оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх | - | Мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаандаа ирүүлсэн эсэх /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| **5. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 9 | Аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийн бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх | ОНТ | Бэлэн байдлын үзлэг, иж бүрэн сургуулийн үнэлгээний хувь | - | 100 | Сумын ЗДТГ |
| | | | Хөрөнгө шийдвэрлэсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | |
| 10 | Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон, /хүн хүч, техник хэрэгсэлийн томилгоо, судалгаа, дайчлан ажиллуулах хүн, техник хэрэгсэл, аюулт үзэгдэл, ослын дуудлагаар хүн хүч, яаралтай цугларах, утсаар болон биеэр дуудах схем/ шинээр боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Онцгой байдлын газраар хянуулан батлах | ОНТ | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлуулсан эсэх | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| 11 | Гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангахтай холбогдуулан сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг аюулт үзэгдэл, ослын дуудлагаар ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг /хувцас, техник, багаж хэрэгсэл, сургалт дадлага гэх мэт/ хангуулах | ОНТ | Бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан хувиар | 68 | 75 | Сумын ЗДТГ |
| 12 | Сумын гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй | ОНТ | Тайлан мэдээг ирүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ, бэлтгэл бэлэн байдлын талаар аймгийн Онцгой комисст улирал бүр тайлан ирүүлж ажлаа дүгнүүлэх | | | | | |
| **6. Батлан хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх** | | | | | | |
| 13 | Төрийн цэргийн байгууллын үйл ажиллагааг сумын иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах | | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | 0 | 1 | Сумын ЗДТГ |
| 14 | Зэвсэгт хүчний 103 жилийн ой, Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ой, чөлөөлөх дайны 79 жилийн ойн баярын арга хэмжээг тус бүр тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах, хүүхэд залууст сурталчлах | | Дайчилгааны тухай хуулийн 28.1.3 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 33.8. дахь хэсэгт тус тус заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна. Хугацаа: Жилдээ | 0 | 15 | Сумын ЗДТГ |
| 15 | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулах | | Хүүхэд залуучуудад зохион байгуулсан арга хэмжээ нь тодорхой мэдлэг, эх орноороо бахархах сэтгэгдэл төрүүлсэн байх | 0 | 1 | Сумын ЗДТГ |
| 16 | Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний I шатыг зохион байгуулах, шалгарсан баг тамирчдыг аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний II шатны тэмцээнд оролцуулах | | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | 0 | 2 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | Цэргээс халагдаж буй залуусын хөдөлмөр эрхлэлтэд анхаарч ажлын байранд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах МСҮТөв, ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах | | Тэмцээний удирдамжийн дагуу сургуулиуд баг тамирчидаа бэлтгэж бүрэн хамрагдсан байна | 0 | 1 | Сумын ЗДТГ |
| 18 | Хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын ар гэрт халамж үйлчилгээ тусламж үзүүлэх | | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | 0 | 2 | Сумын ЗДТГ |
| | | | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | 0 | 1 | |

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

**2 дугаар хавсралт**

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2024 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БОДЛОГО, ШИЙДВЭР БАТАЛЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧИЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.** | | | | | | |
| 1.1 | Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал, шийдвэрийг батлагдсан хуваарийн дагуу Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг бууруулах арга хэмжээ авах | | Зөрчилтэй шийдвэрийн бууралтын хувь (сумдын дундаж) | 20 | 18 | Сумын ЗДТГ |
| 1.2 | Иргэд, олон нийтийг хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээ, зөвлөгөө мэдээллээр хангах эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах | | Эрх зүйн сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь | 21 | 23 | Сумын ЗДТГ |
| 1.3 | Сумдын “Эрх зүйн хөтөч” нарыг нэгдсэн арга хэмжээнд хөтөлбөр, хуваарийн дагуу багийн зохион байгуулалтаар ажиллуулж, баг бүрд үйл ажиллагаа зохион байгуулах | | Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 4 | Сумын ЗДТГ |
| 1.4 | Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь | 60 | 70 | Сумын ЗДТГ |
| 1.5 | ХЗДХЯ, Авлигатай тэмцэх газар бусад байгууллагуудаас хүргүүлсэн тв шторк, CD, инфографик, кино, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг) лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулж олон нийтэд хүргэх | | Сайт, цахим хуудсанд байршуулан сурталчилсан мэдээллийн тоо | 60 | 60 | Сумын ЗДТГ |
| 1.6 | Сумын ЗДТГ-аас хууль тогтоомжоор бэлтгэсэн цахим гарын авлага, шторк, тик ток зэрэг сурталчилгааны | | | 2 | 4 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг иргэд, олон нийтэд таниулж хүргэх | | | | | |
| **ЗОРИЛТ 2. ТӨРИЙН АЛБАНД ШУДАРГА ЁС, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЖ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛНЭ.** | | | | | | |
| 2.1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, хэрэгжилт үр дүнг (ИТХ-ын дэргэдэх зөвлөл, Засаг даргын зөвлөл)-өөр хэлэлцүүлэн үнэлүүлж тайлагнах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (сумын дүн) | 90 | 95 | Сумын ЗДТГ |
| 2.2 | Авлигатай тэмцэх газар болон аймгийн ЗДТГ-аас санаачилсан авлигын эсрэг аян, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг иргэд, хүүхэд залуусыг хамруулан зохион байгуулж, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | | Самбар ажиллуулсан эсэх (сум бүр) | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | 5 | Сумын ЗДТГ |
| | | | Хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо (аймгийн дүн) | 300 | 300 | Сумын ЗДТГ |
| 2.3 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг/ХАСУМ/-ийг хянуулж, томилогдсон албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулах | | ХАСУМ-ийг хянуулсны дараа томилогдсон албан тушаалтны эзлэх хувь | 100 | 100 | Сумын ЗДТГ |
| | | | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлсэн хувь | 100 | 100 | Сумын ЗДТГ |
| **ЗОРИЛТ 3. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛНЭ.** | | | | | | |
| 3.1 | Сумдад ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай урсгал зардлыг шийдвэрлэх | | Шаардлагатай урсгал зардлыг шийдвэрлэсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| 3.2 | Тухайн сумд томилогдсон цагдаагийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах | | Ажлаар хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| 3.3 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхэд, иргэдийг хамгаалах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах ажлыг холбогдох төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, хяналт оролцоог | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, үр дүн | 4 | 5 | Сумын ЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтмолжуулах | | | | | |
| 3.4 | Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр идэвхи санаачилгатай ажиллаж АА бүлгийг байгуулан тэдэнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | | АА бүлэгтэй болсон эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумын ЗДТГ |
| | | | Зохион байгуулсан арга хэмжээ | 2 | 2 | Сумын ЗДТГ |
| 3.5 | Нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нөлөөлийн ажил, арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, үр дүн | 2 | 2 | Сумын ЗДТГ |
| 3.6 | Сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, замын теле-камержуулах зорилгоор "Ногоон бүс" төслийг хэрэгжүүлж гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх | | Нэмэгдүүлсэн камер, гэрэлтүүлгийн тоо | 10 | 15 | Сумын ЗДТГ |
| **ЗОРИЛТ 4. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЖ, УДИРДЛАГЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛНА.** | | | | | | |
| 4.1 | Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх удирдамж гарган хэрэгжилтийг хангах | - | Арга хэмжээ зохион байгуулсан хэрэгжилтийн хувь | - | 100 | Сумын ЗДТГ |
| 4.2 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 5.6-д заасны дагуу 1-ээс 2 хадгаламжийн нэгж бүхий тусгай төрлийн баримт бүрдүүлж ажиллах (кино, дуу дүрсний бичлэг, гэрэл зураг) | - | 1-2 хадгаламжийн нэгж бүхий тусгай төрлийн баримт бий болгосон байх | - | 2 | Сумын ЗДТГ |

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС**

**3 дугаар хавсралт**

НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2023 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | |
| 1.1 | Аймгийн “Шатар” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх | | Шатрын сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 50 | Сумын ЗДТГ |
| | | | Шатрын тэмцээнийг насны ангиллаар зохион байгуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | |
| 1.2 | “3х3” сагсан бөмбөгийн спортыг орон нутагт хэрэгжүүлэх | | 3х3 сагсан бөмбөгийн спортоор хичээллэгчдийн тоо | - | 20 | Сумын ЗДТГ |
| | | | 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд оролцогчдын тоо | | 16 | |
| 1.3 | Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 заалтын хүрээнд суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах | | Орон тооны арга зүйч томилон ажиллуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Сумын ЗДТГ |
| 1.4 | Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, олон төрөлт спортын орчин нөхцлийг сайжруулах, бүх нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах | | Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан тоо | | 2 | Сумын ЗДТГ |
| **ХОЁР. СОЁЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | |
| 2.1 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | | Тооллогыг удирдамжийн дагуу хийж, тайланг ирүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Сумын ЗДТГ СТ |
| 2.2 | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | Орон нутгийн оролцоог хангаж, дэмжлэг үзүүлсэн эсэх | 1 | 1 | Сумын ЗДТГ СТ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (тийм-1, үгүй-0) | | | |
| 2.3 | Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт эрэгтэй уртын дуучин Жигзавын Дорждагвын мэндэлсний 120 жилийн ойн хүрээнд түүний хөдөлмөр бүтээлийг сурталчлах арга хэмжээ зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Сумын ЗДТГ СТ |
| 2.4 | Нийт иргэдийн дунд угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 2 | Сумын ЗДТГ СТ |
| | | | Хөтөлсөн өрхийн эзлэх хувь | | 56.1 | |
| 2.5 | Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 3 | Сумын ЗДТГ |
| **ГУРАВ. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 3.1 | Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж, хүүхдийн тусламжийн 108-д ирүүлсэн дуудлагыг тухай бүр чанартай шийдвэрлэх | - | “Хүүхдийн тусламжийн утас -108” болон бусад санал, өргөдөл, гомдол, кейс шийдвэрлэлтийн хувь | 90 | 100 | Сумын хамтарсан багийн гишүүд |
| | | - | Хуралдааны шийдвэрийн тоо | 1 | 3 | |
| 3.2 | Хүүхдийн чуулган зохион байгуулан “Хүүхдийн элч” сонгон журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Чуулганы тоо | - | 1 | Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд |
| | | - | Хүүхдийн элчийн зохион байгуулсан арга хэмжэжний тоо | - | 2 | |
| 3.3 | Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах | - | Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан наадмын тоо | 1 | 1 | Сумын хамтарсан багийн гишүүд |
| | | - | Мэдээллийн санд бүртгүүлсэн уралдаанч хүүхдийн тоо | 30 | 35 | |
| 3.4 | Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг бүх түвшинд дэмжиж “Хүчирхийлэлгүй сум” арга хэмжээг зохион | - | Эцэг эхийн зөвлөл | - | 5 | Сумын хамтарсан багийн гишүүд |
| | | - | Арга хэмжээний тоо | - | 2 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | | | | | |
| 3.5 | “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг бүх түвшинд зохион байгуулах | - | Санаачлан зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | Сумын хамтарсан багийн гишүүд |
| | | | Бууруулсан эрсдэлийн тоо | 1 | 5 | |
| 3.6 | Миний гэрийн хаяг плакат хийж хүүхдэд тараах /палкат дээр шаардлагатай байгууллагын утас, хаяг бичих/ | | Палкат хийсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Сумын ЗДТГ |
| | | | Тараасан хүүхдийн тоо | - | 100 | |
| **ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | |
| 4.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог хангах орон тооны бус дэд салбар зөвлөлийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг улирал бүр тайлагнах | - | Тайлагнасан тоо | - | 4 | Сумын ЗДТГ |
| 4.2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Сумын ЗДТГ |
| 4.3 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг малчдад сурталчлах | - | Сургалт, сурталчилгааны тоо | - | 2 | Сумын ЗДТГ |
| | | | Малчдын НДатгалд хамралтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | - | 100 | |
| 4.4 | Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсэн тоо | - | 2 | Сумын ЗДТГ |
| 4.5 | Зорилтот бүлгийн ажилгүй иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах | - | Сумдад хувиарлагдсан квотын дагуу зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан хувь | - | 100 | Сумын ЗДТГ |
| **ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 5.1 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд Эрүүл мэндийн | | Хийсэн сургалт сурталчилгааны тоо | - | 8 | Сумын ЗДТГ НЭ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын тухай хуулийн сургалт, сурталчилгаа хийж, эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх | | ЭМД-д өмнөх оноос нэмэгдүүлэх хамрагдалтын хувь | 5729 | 9800/41,5 | |
| 5.2 | Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх | | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь | 65,0 | 67,0 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.3 | Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээг 2024 оноос орон даяар хэрэгжүүлэх болсонтой холбоотой хэрэгжилтийг ханган ажиллах | | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 41278 | 43000 | |
| | | | Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгосон хувь | 87,5 | 88,0 | |
| 5.4 | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх бий болгох шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах | | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь | 15.2 | 24.1 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.5 | Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | | Үзлэгт хамрагдалтын хувь | 21,0 | 29,8 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.6 | Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх | | Хүний нөөцийн хангалтын хувь | 91,0 | 92,3 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.7 | Шинээр төгсөн очиж буй эмч мэргэжилтнүүдийг орон байраар хангах | | Орон байраар хангасан мэргэжилтний тоо | 1 | 2 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.8 | Нэн шаардлагатай байгаа сувилагч мэргэжилтэнг бэлтгэх | | Сувилагчийн хангалтын хувь | 4 | 5 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.9 | Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг бууруулах | | Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлтөд/ | 0 | 0 | Сумын ЗДТГ НЭ |
| | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /100 амьд төрөлтөд/ | 0 | 0 | |
| 5.10 | Цусны сайн дурын донорын тоог нэмэгдүүлэх | | Донорын тоо | 21 | 24 | Сумын ЗДТГ НЭ |
| 5.11 | Амрах байрыг тохижуулж, амарсан жирэмсэн эхчүүдийн тоог нэмэгдүүлэх | | Эхийн амрах байрны тохижилтийн хувь | 50 | 80 | Сумын ЗДТГ НЭ |
| | | | Амрах байраар амарсан эхийн тоо | 7 | 15 | |
| 5.12 | Түргэн тусламжийн автомашин эвдрэл хэмхрэл гарсан тохиолдолд автомашины | | Дэмжлэг үзүүлсэн тоо | 1 | 5 | Сумын ЗДТГ НЭ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэг үзүүлж ажиллах | | | | | |
| 5.13 | Сумын эрүүл мэндийн төвд өндөр өртөгтэй тоног төхөөрөмжөөс бусад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх | | Тоног төхөөрөмжөөр хангалтын хувь | 89,0 | 90,0 | Сумын ЗДТГ НЭ |

## НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

**4 дүгээр хавсралт**

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ
(Дэлгэрхангай сум)

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2024 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль дүрэм журмын дагуу зарцуулж өр авлагагүй ажиллах** | | | | | | |
| 1.1 | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан 2024 оны орон нутгийн төсвийн орлого болон улсын төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр бүрэн төвлөрүүлэх. | | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 95.5 | 100 | СТСХ |
| | | | Биелсэн төсвийн орлогын нэр төрлийн эзлэх хувь | 55.6 | 90 | СТСХ |
| 1.2 | Хуульд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тайлангууд, төлбөрийг бүрэн барагдуулах | | Хуулийн хугацаандаа тайлагнасан тайлангуудын ирцийн хувь | - | 100 | СТСХ |
| 1.3 | Сум орон нутагт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдийг борлуулалтын орлогыг цахим төлбөрийн баримтын систем /Е-баримт/-д бүртгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах | | Аж ахуй эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, тохирлын гэрчилгээ олгох зэрэг төрийн үйлчилгээг үзүүлэх бүртээ цахим төлбөрийн баримт олгож байдалд хяналт тавьсан хувь | - | 100 | СТСХ |
| | | | Татварын албатай хамтран малчдын өдөрлөг, бизнес эрхлэгчдэд зориулан зохион байгуулсан өдөрлөгийн тоо | - | 2 | СТСХ |

**5 дугаар хавсралт**

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

(Дэлгэрхангай)

| № | Зорилт, ажил, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Хүрэх түвшин | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | |
| НЭГ. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 1.1 | Бэлчээр хашиж хамгаалах | Тухайн жилд хашсан талбайн хэмжээ га | Га | 2023 | 0 | 2 | Сумын ЗДТГ |
| 1.2 | Тэжээлийн ургамал тариалах | Тариалсан талбайн хэмжээ га | Га | 2023 | 2 | 1 | |
| | | Хураан авсан ургац тн | тн | 2023 | 0 | 2,2 | |
| 1.3 | Гүн өрмийн худаг шинээр гаргах, энгийн уурхайн худаг сэргээн засварлах | Шинээр гаргасан худгийн тоо | Тоо | 2023 | 4 | 1 | Сумын ЗДТГ |
| | | Сэргээн засварласан худгийн тоо | Тоо | 2023 | 5 | 2 | |
| 1.4 | Сум тус бүрээр сүргийн эргэлтийн тооцоо гаргаж, бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах | Эдийн засгийн эргэлтэд оруулж, хэрэгцээлсэн мал хувиар | хувь | 2023 | 18,5 | 19 | Сумын ЗДТГ |
| 1.5 | Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед ялган суурилах | Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгч хувь | хувь | 2023 | 50 | 55 | Сумын ЗДТГ |
| 1.6 | Монгол адууны үүлдэрлэг байдлыг алдагдуулахгүй байх, генефондыг хамгаалах | Малчдад сургалт зохион байгуулах | Сургалтанд хамрагдсан малчдын тоо | 2023 | 0 | 150 | Сумын ЗДТГ |
| ХОЁР. ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛВЭРЛЭЛ, ХОРШООНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 2.1 | Төмс, хүнсний ногоо, малын тэжээл, жимс жимсгэний тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх | Тариалсан талбайн хэмжээ | Га | 2023 | 2,2 | 5,9 | Сумын ЗДТГ |
| | | Хураан авсан ургацын хэмжээ /тн/ | Тн | 2023 | 11,3 | 14,4 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Орон нутгийн онцлогтой хоршоодыг байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | Тоо | 2023 | 0 | 1 | Сумын ЗДТГ |
| 2.3 | Хоршоог хөгжүүлэх сангийн зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай бүрэн нэгтгэх ажлыг зохион байгуулах, сангийн эргэн төлөлтийг сайжруулах, хугацаа хэтэрсэн зээлдэгч, зээлийн дүнг бууруулах | Эргэн төлөлтийн хувь (Хамгийн багадаа 5 хувь өсөх) | Хувь | 2023 | 65 | 70 | Сумын ЗДТГ |
| 2.4 | Газар тариалан үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хүлэмж бий болгох | Байгуулсан хүлэмжийн тоо | тоо | 2023 | - | 2 | Сумын ЗДТГ |
| 2.5 | Газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр трактор болон бусад тоног төхөөрөмжөөр хангах | Тоног төхөөрөмжөөр хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | | 2023 | - | 1 | Сумын ЗДТГ |
| 2.6 | Албан хаагч, иргэдийг хүлэмж болон ил талбайд ногоо тариалах талаар сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 2023 | - | 20 | Сумын ЗДТГ |
| ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 3.1 | Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалт, өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, нөөцлөлт, хадгалалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлтгэсэн байдал /хувь/ | Хувь | 2023 | 84 | 100 | Сумын ЗДТГ |
| 3.2 | Малчдад баталгаажсан үүлдэр омгийн мал, түүнийг өсгөн үржүүлэхийн ач холбогдол, холбогдох стандарт, дүрэм журмыг сурталчилан таниулах | Малчдыг сургалтанд хамруулсан тоо | Тоо | 2023 | 0 | 2 | Сумын ЗДТГ |
| 3.3 | Вакцин хадгалах хөргүүртэй болгох | Хөргүүртэй болсон эсэх Тийм-1 үгүй-0 | 1 | 2023 | | 1 | Сумын ЗДТГ |

**6 дугаар хавсралт**

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

| № | Зорилт, ажил, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Суурь түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|

| | | | Хэмжих нэгж | Он | Түвшин | Хүрэх түвшин | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|
| ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| 1 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, дагалдах журмын хэрэгжилтийг 100 хувьд хүргэх | Хэрэгжилтийн хувь | Хувь | 2023 | 100 | 100 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 2 | Төлөвлөгөөнд тусгагдаагүй байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн орлогын хэсгийг тухайн сум, орон нутгийн байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах | Тогтоолын тоо | Тоо | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 3 | 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогын хэсгээр зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заасан хугацаанд оруулах (www.eic.mn); | Мэдээллийн сан бүрдэлтийн хувь | Хувь | 2023 | 80 | 100 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 4 | Суманд дахивар цуглуулах цэг байгуулж, Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлэх | Дахивар цуглуулах цэг байгуулсан эсэх | /тийм-1, үгүй-0/ | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| | | Дахин боловсруулах үйлдвэрт тушаасан дахиврын хэмжээ | тн | 2023 | - | 2 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 5 | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх, хураамжийн орлогыг зориулалтын дагуу бүрэн зарцуулах | Биелэлтийн хувь | Хувь | 2023 | 23 | 100 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 6 | Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх | ААН иргэнтэй гэрээ байгуулж ажилласан эсэх | /тийм-1, үгүй-0/ | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 7 | Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын хэрэгжилтийг хангуулах | ХХОНБ томилон ажиллуулсан эсэх | /тийм-1, үгүй-0/ | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 8 | Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, гуравдугаар зэрэглэлийн хог | Ландфилл байгуулсан эсэх | /тийм-1, үгүй-0/ | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгуулах | | | | | | |
| 9 | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг аргачлалын дагуу бодитой тогтоож шинэчлэн батлах | Шинээр баталсан эсэх | /тийм-1, үгүй-0/ | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 10 | Эко жорлон арга хэмжээ хэрэгжүүлж стандарын шаардлага хангасан жорлон, ариун цэврийн байгууламжыг нэмэгдүүлэх | Эко жорлонгийн тоо | Тоо | 2023 | 4 | 5 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 11 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах | Шинээр байгуулсан мод үржүүлгийн тоо | Тоо | 2023 | - | 1 | Сумын Засаг даргын тамгын газар |
| 12 | Уст цэгийн тооллогыг холбогдох газруудтай хамтран явуулах, усны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Хамрагдсан сумын тоо | Тоо | 2023 | 5020 | 6000 | Сумын Засаг даргын тамгын газар |